



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөвсгөл аймгийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 16,273,500.00 (арван зургаан сая хоёр зуун далан гурван мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ, 7,006,645.73 (долоон сая зургаан мянга зургаан зуун дөчин таван төгрөг далан гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Хөвсгөл аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор Ч.Алтансүх, “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132051333
12-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны... дугаар сарын ...ны/ний өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨААТҮГ-Т БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, төрөл	Үйлдвэрлэгд- сэн, ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	LEXUS, LX570 маркийн суудлын автомашин	2010/2010	JTJHY00W7A4051776	2761ХӨҮ	16,273,500.00	7,006,645.73	9,266,854.27
НИЙТ ДҮН							
					16,273,500.00	7,006,645.73	9,266,854.27
					(арван зургаан сая хоёр зуун далан гурван мянга таван зуу)	(долоон сая зургаан мянга зургаан зуун дөчин таван төгрөг далан гурван мөнгө)	(есөн сая хоёр зуун жаран зургаан мянга найман зуун тавин дөрвөн төгрөг хорин долоон мөнгө)